



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/262

Хэрлэн сум

Хэлэлцүүлэг зөвлөгөөнд хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 04 дүгээр, “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилтийг орон нутаг хангуулах, аймаг орон нутагт баримтлах бодлого чиглэлийг танилцуулах, мэдээлэл өгөх, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэх зорилгоор зохион байгуулж буй Бичил уурхай эрхлэгчдийн хэлэлцүүлэг, зөвлөгөөний зардалд 5,690,000 (таван сая зургаан зуун ерэн мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



۲۶۲/۲

رئیس تہذیبیہ امور ہونے کے اعتبار سے

[illegible][illegible]

۵.. خدمتگزاران و محرمین در محنت سوزی در سوخته‌های دین سوخته‌های دین و محنت سوزی ..

[illegible]

Handwritten text in Urdu: "میں نے اس کو دیا ہے" (I have given it to him)

05 Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 08 -ний өдрийн
A/262 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Цайны завсарлага	ш	200	8000	1 600 000
2	Үдийн хоол	ш	100	33 000	3 300 000
3	Танхимын түрээс	цаг	6	100 000	600 000
4	Цэвэр ус	ш	100	1900	190 000
	Бүгд				5 690 000